



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Айвуун ТББ

“Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данс”-нд мониторинг хийх төсөл

1. Төслийн Товч танилцуулга

Өнөөдөр Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь Монголын ядуучуудын эгнээнд амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ядуурлаас гаргах нэг чухал хүчин зүйл бол тэдний хөдөлмөр эрхлэх боломж, чадвартай хэсэгт тохирсон ажлын байраар хангах юм.

“ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ”-ийн “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр” гэсэн 111 дүгээр зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй байгууллагуудад зохих хэмжээний ажлын байрны төлбөр оногдуулахаар заасан байдаг ба энэ төлбөрөөр бүрдсэн хөрөнгийг тус хуулийн 111.4-р зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна гэж хуульчилжээ. Энэ төлбөрөөр бүрдэх “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тусгай данс”-ны бүрдүүлэлт, зарцуулалт нь хэрхэн яаж явагдаж хэн ямар ашиг хүртээд байгаа талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний байгууллагуудад нээлттэй биш байдаг. Засгийн газрын тогтоолоор үүссэн тусгай данс ба түүнд хуримтлагдсан хөрөнгө, зарцуулалтанд мониторинг хийснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тодорхой хэсгийн амьжиргааны түвшин дээшилнэ гэж бид итгэж байна. Тэрчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын төрийн бодлого, үзэл баримтлалыг боловсронгуй болгох, түүний үр ашиг, нөлөөг сайжруулахад хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

Ирландын Хөгжлийн Хамтын Ажиллагааны байгууллагаас ОУХБ-ын шугамаар 2003 онд Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар гаргасан баримт бичигт Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйл чухал заалт болохыг тэмдэглэсэн байдаг. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар ч дурдсан байгаа.

2. ЗОРИЛГО

2005 оны байдлаар Монгол Улсын хүн амын 2,8 хувийг эзэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 26,4 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн албан ёсны судалгааны статистик мэдээ байдаг. Хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ доогуур байгаа юм. Энэ байдлаас гарахад нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хязгаарлагдмал чадавх боломжийг ойлгож тэдний онцлог хэрэгцээнд тохирсон хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээг үзүүлэхэд санхүүгийн нэг чухал эх үүсвэр нь “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данс”-ны хуримтлал байх ёстой. Гэтэл энэ дансанд хуримтлал үүсдэггүй гэсэн зүй бус шалтгаанаар зээл, тусламж хүссэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдний байгууллагуудын хүсэлтийг хүлээн авдаггүй асуудлын учир шалтгааныг олж тодорхойлж, хуулийн зүйл заалтыг бодитой хэрэгждэг болгоход энэхүү мониторингийн гол зорилго оршино.

Энэ мониторингийг хийснээр дараах үр дүнгүүдэд хүрнэ:

- Үнэхээр тусгай дансанд хуримтлал үүсэхгүй байгаа бол хууль яагаад зөрчигдөөд байгаа, ямар цоорхой байгааг олж тогтооно. Ямар арга хэмжээ авбал хуримтлал зохих ёсоороо үүсэх ёстойг илрүүлж гаргана.
- Тусгай данс бүрдэж байгаа тохиолдолд түүний зарцуулалт хэрхэн хийгдэж, юунд зарцуулагдаж байгааг баримтаар тогтоох. Яагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ данстай холбоотой асуудлаар сэтгэл дундуур байж, хууль зөрчигдөж байгаа тухай гомдол гаргаж байгаа шалтгааныг олж тогтооно.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Тусгай дансны хуримтлалаас хуулийн дагуу зээл, тусламж авдаг болох нөхцөлийг хангах
- Тусгай дансны хуримтлал ба зарцуулалтыг ил тод болгох арга хэмжээ авах

3. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА

Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансны үйлчилгээнд оролцогч талууд ба түүнд хандсан талуудтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, газар дээр нь очиж судлах, анкетын асуулга авах, хоёрдогч мэдээлэл баталгаажуулах баримт цуглуулах аргуудаар мониторинг хийнэ. Тусгай данстай холбоотой хууль, тогтоолууд, тушаалууд, дүрмүүдийг цуглуулан авч дүн шинжилгээ хийнэ. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудаас гаргасан тайлангуудад тоон ба чанарын судалгааг нарийн явуулна.

Энэ чиглэлээр өмнө нь Олон улсын болон бусад байгууллагуудаас явуулж байсан судалгааны ажлын үр дүнг ашиглах, харьцуулах судалгаа хийнэ. Дэлхийн бусад улсуудын туршлага, практикаас судлаж манай улсын хэрэгжүүлж байгаа квотын тогтолцоо нь Олон улсын жишгээр ямар хэмжээнд байгаа, ямар арга хэмжээ авбал энэ жишигт хүрч очих талаар холбогдох баримт бичигт судалгаа явуулна.

Мониторингийн дээрх аргуудыг нэгтгэн дүгнэвэл:

- ✧ Холбогдох баримт бичгийг цуглуулах
- ✧ Баримт бичгийн шинжилгээ хийх
- ✧ Адил төсөөтэй квотын тогтолцоог бусад улс орнууд хэрхэн хэрэглэдэг арга туршлагыг судлах, харьцуулах, манай нөхцөлд зохимжтой зүйлсийг авч ашиглах талаар судалгаа хийх
- ✧ Бүлгийн ярилцлага зохион байгуулах
- ✧ Асуулга авах
- ✧ Анхдагч мэдээлэлд дүн шинжилгээ хийх буюу Статисткийн болон бусад холбогдох байгууллагуудаас гаргаж буй мэдээ, тайланг ашиглах болно.

Судалгаагаар гарсан үнэлэлт, дүгнэлт дээрээ үндэслэн төрийн бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх шатанд ямар алдаа байгааг тодруулан гаргаж түүнийг арилгах арга замын талаар тодорхой зөвлөмж гаргана. Хуулийн зүйл заалтын хэрэгжилттэй холбоотойгоор гарч байгаа алдаа дутагдлыг арилгах, засах арга хэмжээг ямар баримт бичигт хийх хэрэгтэй байгааг тодруулан заана.